



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 59

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХҮРМЭН СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.МӨНХЗУЛ  
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрмэн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хүрмэн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын нэмэлт дансаар нутгийн удирдлагын 30 жилийн ойн хандив авч чиг үүрэгт хамааралгүй, ажил гүйлгээг гүйцэтгэсэн, үйл ажиллагааны нэмэлт орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас олгосон, уран бүтээл хийлгэх зардлаас өргөмжлөл, жааз, свунер, туг, материалын үнэ, уралдааны мөнгөн шагнал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, зөөлөн эдлэл нормын хувцас, хөдөлмөр хамгааллын зардлаас цэвэрлэгээ, аж ахуйн материал бэлтгэсэн, бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20.1.2, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

016020097

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Хүрмэн суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт гаргаснаар тус соёлын төвд 11.0 сая төгрөгийн хандив хүлээн авч нэмэлт санхүүжилтийн дансаараа дамжуулан Хүрмэн сумын түүхт 99 жилийн ой, Монгол цэргийн баярын 101 жилийн ой, Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан "Уран гартан Хүрмэнчүүд-2022" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, бүх нийтийг хамарсан арга хэмжээ, шагнал урамшуулалд тус тус зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0.5 сая, Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн төслөөр 94.2 сая, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор үнэ тогтоосон 31.9 сая, музейн үзмэр, иргэдийн хандиваар 2.2 сая нийт 128.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий үндсэн хөрөнгө шинээр бэлтгэж бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,991,450.00</u></b>	<b><u>3,469,346.79</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	1,369,166.79
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	1,369,166.79
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	1,369,166.79
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,369,166.79
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,991,450.00	2,100,180.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,991,450.00	2,100,180.00
35410	Бичиг хэргийн материал	81,000.00	36,000.00
35420	Аж ахуйн материал	1,211,000.00	1,466,000.00
35440	Түлш, шатах тослох материал	101,270.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	598,180.00	598,180.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>476,039,828.56</u></b>	<b><u>566,793,602.35</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	476,039,828.56	566,793,602.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	469,493,828.56	560,247,602.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	396,220,857.39	396,220,857.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,953,987.56	-28,573,619.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,500,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,854,166.77	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,249,040.00	73,068,940.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,560,698.52	-1,940,269.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,712,359.00	72,667,359.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,808,341.72	-8,112,655.63
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,105,500.00	20,735,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,085,160.00	25,910,160.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,243,161.26	-2,344,937.06
39217	Ном	12,041,268.00	12,616,268.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,546,000.00	6,546,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,546,000.00	6,546,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>478,031,278.56</u></b>	<b><u>570,262,949.14</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>478,031,278.56</u></b>	<b><u>570,262,949.14</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	478,031,278.56	570,262,949.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	284,029,036.55	284,029,036.55
51101	Өмч: - төрийн	284,029,036.55	284,029,036.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	194,002,242.01	286,233,912.59
51210	Өмнөх үеийн үр дүн	194,002,242.01	194,002,242.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	92,231,670.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>478,031,278.56</u></b>	<b><u>570,262,949.14</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>119,906,779.00</b>	<b>265,983,205.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,040,499.00</b>	<b>128,222,140.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,040,499.00	128,222,140.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,040,499.00	128,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,500.00	128,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,339,999.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>102,866,280.00</b>	<b>137,761,065.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	84,103,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	84,103,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,815,680.00	21,313,065.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	19,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,815,680.00	1,948,065.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	365,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	101,050,600.00	31,544,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,050,600.00	31,544,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	800,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	800,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>127,843,938.44</b>	<b>159,855,701.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>127,843,938.44</b>	<b>159,855,701.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	120,500,660.86	156,331,213.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	56,639,170.00	65,869,177.63
210101	Үндсэн цалин	56,639,170.00	45,612,885.15
210102	Нэмэгдэл	00.00	15,793,866.48
210104	Урамшуулал	00.00	4,462,426.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,323,344.00	8,230,257.58
210201	Тэтгэврийн даатгал	5,057,774.00	5,652,894.47
210202	Тэтгэмжийн даатгал	566,392.00	586,753.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	453,114.00	534,461.00
210204	Ажилгүйдлийн даатгал	113,280.00	124,222.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,132,784.00	1,331,927.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,930,923.42	26,660,095.06
210301	Гэрэл, цахилгаан	314,343.42	779,049.06
210302	Түлш, халаалт	24,613,580.00	24,781,046.00
210303	Цэвэр, бохир ус	1,003,000.00	1,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,601,140.00	2,985,750.00
210401	Бичиг хэрэг	158,500.00	285,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,848,340.00	1,900,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	359,300.00	360,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	308,000.00	1,124,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,000.00	1,124,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	694,000.00	1,611,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,098,100.00
210604	Урсгал засвар	694,000.00	513,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	42,000.00	28,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	28,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	892,015.00	5,198,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	892,015.00	5,198,750.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,070,068.44	44,623,133.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	789,700.00	20,604,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,280,368.44	24,019,033.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,343,277.58	3,524,487.94
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,605,680.00	2,715,169.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,605,680.00	2,715,169.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,737,597.58	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,737,597.58	00.00
213304	Хөрөнгийн	00.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	809,318.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	809,318.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-7,937,159.44</b>	<b>106,127,503.77</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	13,895,833.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	13,895,833.19
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-13,895,833.19
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-7,937,159.44</b>	<b>92,231,670.58</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>103,566,780.00</b>	<b>137,889,565.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>700,500.00</b>	<b>128,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	700,500.00	128,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	700,500.00	128,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,500.00	128,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>102,866,280.00</b>	<b>137,761,065.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	84,103,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	84,103,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,815,680.00	21,313,065.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	19,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,815,680.00	1,948,065.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	365,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	101,050,600.00	31,544,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,050,600.00	31,544,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	800,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	800,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>103,566,780.00</b>	<b>136,020,398.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>103,566,780.00</b>	<b>136,020,398.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>96,223,502.42</b>	<b>132,495,910.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	56,555,172.00	66,022,462.43
210101	Үндсэн цалин	41,894,333.00	45,766,169.95
210102	Нэмэгдэл	14,660,839.00	15,793,866.48
210104	Урамшуулал	00.00	4,462,426.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,323,342.00	8,076,972.78
210201	Тэтгэврийн даатгал	4,946,142.00	5,499,609.67
210202	Тэтгэмжийн даатгал	595,200.00	586,753.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	475,200.00	534,461.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118,800.00	124,222.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,188,000.00	1,331,927.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,930,923.42	26,660,095.06
210301	Гэрэл, цахилгаан	284,039.38	1,178,495.06
210302	Түлш, халаалт	24,626,884.04	24,681,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,020,000.00	800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,769,250.00	2,774,480.00
210401	Бичиг хэрэг	239,500.00	240,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,795,450.00	1,799,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	375,000.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	359,300.00	360,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	758,000.00	1,124,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	758,000.00	1,124,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	1,611,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,098,100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	513,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	42,000.00	28,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	28,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,192,015.00	5,198,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,192,015.00	5,198,750.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	652,800.00	20,999,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	652,800.00	20,999,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,343,277.58</b>	<b>3,524,487.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,605,680.00	2,715,169.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,605,680.00	2,715,169.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,737,597.58	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,737,597.58	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	809,318.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	809,318.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>1,869,166.79</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	500,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-500,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	1,369,166.79
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,369,166.79

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>284,029,036.55</b>	<b>194,002,242.01</b>	478,031,278.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>284,029,036.55</b>	<b>194,002,242.01</b>	478,031,278.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	92,231,670.58	92,231,670.58
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>284,029,036.55</b>	<b>286,233,912.59</b>	570,262,949.14

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	115,648,400.00	114,398,014.27
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	115,648,400.00	114,398,014.27
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	114,880,400.00	113,630,910.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	66,923,300.00	66,022,462.43
210101	Үндсэн цалин	45,322,400.00	45,766,169.95
210102	Нэмэгдэл	17,579,700.00	15,793,866.48
210104	Урамшуулал	4,021,200.00	4,462,426.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,365,500.00	8,076,972.78
210201	Тэтгэврийн даатгал	5,688,600.00	5,499,609.67
210202	Тэтгэмжийн даатгал	669,300.00	586,753.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	535,300.00	534,461.00
210204	Ажилгүйдлийн даатгал	133,800.00	124,222.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,338,500.00	1,331,927.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,112,600.00	26,660,095.06
210301	Гэрэл, цахилгаан	1,631,000.00	1,178,495.06
210302	Түлш, халаалт	24,681,600.00	24,681,600.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,775,000.00	3,274,480.00
210401	Бичиг хэрэг	240,000.00	240,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,799,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	375,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360,000.00	360,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	760,000.00	759,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,000.00	759,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,645,000.00	1,611,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,098,100.00
210604	Урсгал засвар	545,000.00	513,500.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	70,000.00	28,000.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	28,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,229,000.00	5,198,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,229,000.00	5,198,750.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2000000.00	1999100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,999,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	768000.00	767104.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	768,000.00	767,104.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	767,104.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	115,648,400.00	116,576,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	84,103,200.00	84,103,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	84,103,200.00	84,103,200.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	31,545,200.00	31,544,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	31,545,200.00	31,544,800.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	928,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	128,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	800,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,369,166.79

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,313,065.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,313,065.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19,365,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	365,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	365,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,948,065.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,948,065.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,948,065.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	21,313,065.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,313,065.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	19,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,948,065.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	365,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 84.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 84.5 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн гарзыг 0.07 сая төгрөгөөр дутуу илэрхийлж өмнөх үеийн үр дүнг бууруулан тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 0.4 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 131105 тоот дансанд тайлагнаагүй,
- Улсын төсвийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн 84.1 сая төгрөгийг 131001 тоот дансанд тайлагнаагүй байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

#### 5.2 Албан шаардлага

-Нутгийн удирдлагын 30 жилийн ойн арга хэмжээний зардал болох 8.0 сая төгрөгийг байгууллагын нэмэлт дансаар авч чиг үүрэгт хамааралгүй, ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.2 "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

-Тус Соёлын төвийн төлбөрт үйлчилгээний үнэ, тарифыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 32 дугаар тогтоосон боловч төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заасантай нийцэхгүй байна.

-Тус соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны А/22 дугаар тушаалаар албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас 2.0 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

-Уран бүтээл хийлгэх /80214/ зардлаас өргөмжлөл, жааз, свунер, туг, материалын үнэ, уралдааны мөнгөн шагналын зардалд 1.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, зөөлөн эдлэл нормын хувцас, хөдөлмөр хамгааллын зардлаас 1.5 сая төгрөгийн цэвэрлэгээ, аж ахуйн материалыг тус тус худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт 1:* Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг бүрдүүлэхдээ үнэт цаасаар баримтжуулж, үйл ажиллагааны бүртгэл хөтөлж, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үйл ажиллагааны орлогыг үнэт цаасаар баримтжуулж анхан шатны бүртгэл хөтөлж хэвших

*Илрүүлэлт 2:* Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх"-д заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн гарзыг 77.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж өмнөх үеийн үр дүнг бууруулан тайлагнасан,	1	77.7			1	77.7	1	77.7				
Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 365.0 мянган төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 131105 тоот дансанд тайлагнаагүй,	1	365.0			1	365.0	1	365.0				
Улсын төсвийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн 84,103.2 мянган төгрөгийг 131001 тоот дансанд тайлагнаагүй байна.	1	84,103.2			1	84,103.2	1	84,103.2				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>84,545.9</b>			<b>3</b>	<b>84,545.9</b>	<b>3</b>	<b>84,545.9</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг бүрдүүлэхдээ үнэт цаасаар баримтжуулж, үйл ажиллагааны бүртгэл хөтөлж, тайлан гаргаагүй байна.	1	0					1	0				
Нутгийн удирдлагын 30 жилийн ойн хандивыг байгууллагын нэмэлт дансаар авч чиг үүрэгт хамааралгүй, ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.	1	8,000.0			1	8,000.0						
Тус Соёлын төвийн төлбөрт үйлчилгээний үнэ, тарифыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 32 дугаар тогтоосон боловч төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.	1	0			1	0						
Тус соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны А/22 дугаар тушаалаар албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас 2,000.0 мянган төгрөг олгосон байна.	1	2,000.0			1	2,000.0						
Уран бүтээл хийлгэх /80214/ зардлаас өргөмжлөл, жааз, свунер, туг, материалын үнэ, уралдааны мөнгөн шагналын зардалд 1,674.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, зөөлөн эдлэл нормын хувцас, хөдөлмөр хамгааллын зардлаас 1,519.3 мянган төгрөгийн цэвэрлэгээ, аж ахуйн материалыг тус тус худалдан авсан байна	1	3,193.3			1	3,193.3						
Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна.	1	1,674.0					1	1,674.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>14,867.3</b>			<b>4</b>	<b>13,193.3</b>	<b>2</b>	<b>1,674.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд тавигдах 46 мэдээллийг хоцруулан байршуулсан, тухайн жилийн төсөв, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, дараа жилийн төсвийн төсөл, аудитын дүгнэлт түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш орлогын 8,000,0000 төгрөгийн 1 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулсан 8,044,441 төгрөгийн 2 шийдвэр, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус тус оруулаагүй байна.	1	16,044.4			1	16,044.4		
<b>Дүн</b>	1	16,044.4			1	16,044.4		